ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Дундговь аймгийн Өндөршил сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДУА-2025/129/НА-СТА-ТШЗ**


Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592225
Цахим хаяг: Oyun-erdenet@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn

Аудитор Л.Баянмөнх

Утас: 99997540
Цахим хаяг: bayanmunkhamina@gmail.com



Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2025 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2025.02.28 № 53

танай ______ -ны № ______ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.БАТНЯМ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Өндөршил сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад цалингийн зардал өмнөх оноос 151.1 сая төгрөг өссөн нь Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой байна. Мөн авлага 52.3 сая төгрөгөөр өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжих санхүүжилтийн авлага байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

**Бусад асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж

4825020179

үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт, 18 арга хэмжээг тусгаж хэрэгжилтийг хангаж ажилласнаар Өлзийт сумын засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 83.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **102,767,600.35** | **148,287,030.65** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 25,954,839.44 | 17,571,577.86 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 25,954,839.44 | 17,571,577.86 |
| **3121** | **Төгрөг** | 25,954,839.44 | 17,571,577.86 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 21,536,648.54 | 14,558,536.96 |
| 31214 | Ахмадын сангийн харилцах | 4,418,190.90 | 3,013,040.90 |
| **33** | **АВЛАГА** | **10,013,411.70** | **62,411,285.34** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 93,693.70 | - |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 9,919,718.00 | 62,411,285.34 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **66,799,349.21** | **68,304,167.45** |
| **351** | **Түүхий эд материал** | 53,644,803.21 | 58,382,836.45 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 11,999,551.23 | 15,190,057.82 |
| 35130 | Эм боох материал | 41,645,251.98 | 43,192,778.63 |
| **354** | **Хангамжийн материал** | 13,154,546.00 | 9,921,331.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 746,100.00 | 471,600.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 10,620,176.00 | 8,623,676.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,788,270.00 | 826,055.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **264,961,637.22** | **324,096,110.45** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **264,961,637.22** | **324,096,110.45** |
| **392** | **Биет хөрөнгө** | 256,201,637.22 | 315,630,110.45 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 201,740,474.10 | 199,965,444.10 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (144,585,977.09) | (145,045,297.43) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 68,460,790.00 | 137,460,790.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (29,136,930.00) | (50,432,193.29) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 232,225,243.76 | 238,446,335.76 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (86,793,528.70) | (82,633,574.10) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 24,738,365.67 | 25,119,811.07 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (10,446,800.52) | (7,251,205.66) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 8,760,000.00 | 8,466,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 8,760,000.00 | 8,466,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **363,311,046.67** | **472,383,141.10** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **2,244,072.78** | **29,952,496.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **2,244,072.78** | **29,952,496.00** |
| **413** | **Өглөг** | 2,244,072.78 | 29,952,496.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 317,061.78 | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 1,927,011.00 | 29,952,496.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **365,485,164.79** | **442,430,645.10** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **365,485,164.79** | **442,430,645.10** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 192,119,629.88 | 192,119,629.88 |
| 51101 | Өмч:  - төрийн | 192,119,629.88 | 192,119,629.88 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 141,704,706.83 | 218,650,187.14 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 182,412,086.59 | 141,704,706.83 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (40,707,379.76) | 76,945,480.31 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 31,660,828.08 | 31,660,828.08 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **367,729,237.57** | **472,383,141.10** |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **597,328,052.66** | **897,534,088.05** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **85,257,870.27** | **198,766,021.04** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 85,257,870.27 | 198,766,021.04 |

| | | | |
|---|---|---|---|
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 85,257,870.27 | 198,766,021.04 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,246,320.00 | 23,614,600.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 74,011,550.27 | 175,151,421.04 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **512,070,182.39** | **698,768,067.01** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 28,225,400.00 | 36,147,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 28,225,400.00 | 36,147,400.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 483,844,782.39 | 662,620,667.01 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 483,844,782.39 | 662,620,667.01 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **625,503,815.18** | **818,112,407.74** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **625,503,815.18** | **818,112,407.74** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 624,598,415.18 | 796,507,116.72 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 331,199,341.95 | 482,303,515.02 |
| 210101 | Үндсэн цалин | 262,344,355.34 | 301,222,287.96 |
| 210102 | Нэмэгдэл | 54,223,472.74 | 139,050,873.28 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,196,000.00 | 3,775,000.00 |
| 210104 | Урамшуулал | 11,435,513.87 | 38,255,353.78 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 40,228,943.69 | 59,555,061.55 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,384,125.63 | 41,249,386.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,298,624.87 | 4,849,435.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,612,420.90 | 2,943,214.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 539,433.78 | 2,099,437.06 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,394,338.51 | 8,413,588.30 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,352,411.00 | 29,538,097.98 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,700,000.00 | 3,317,097.48 |
| 210302 | Түлш, халаалт | 23,652,411.00 | 26,221,000.50 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 48,479,843.91 | 28,529,090.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,263,200.00 | 2,099,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,672,830.00 | 15,923,790.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 919,000.00 | 1,042,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 270,700.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,772,100.00 | 9,463,300.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 27,582,013.91 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 59,330,266.42 | 60,331,736.36 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 51,384,317.92 | 54,055,120.36 |
| 210502 | Хоол, хүнс | 7,945,948.50 | 6,276,616.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,145,000.00 | 10,627,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,145,000.00 | 10,627,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,654,000.00 | 18,432,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,654,000.00 | 18,432,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,609,355.60 | 2,964,987.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 449,062.00 | 985,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,260,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 108,900.00 | 133,950.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 121,393.60 | 177,593.60 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 545,000.00 | 990,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 70,000.00 | 128,844.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | - | 483,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 100,599,252.61 | 104,225,628.21 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,297,680.00 | 4,825,350.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 96,301,572.61 | 99,400,278.21 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 905,400.00 | 21,605,291.02 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 905,400.00 | 21,498,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 21,498,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 905,400.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 107,291.02 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 107,291.02 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(28,175,762.52)** | **79,421,680.31** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **12,531,617.24** | **2,476,200.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 12,531,617.24 | 2,476,200.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (12,531,617.24) | (2,476,200.00) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(40,707,379.76)** | **76,945,480.31** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **523,316,502.39** | **669,984,793.37** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **11,246,320.00** | **23,708,293.70** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 11,246,320.00 | 23,708,293.70 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 11,246,320.00 | 23,708,293.70 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,246,320.00 | 23,708,293.70 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **512,070,182.39** | **646,276,499.67** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 28,225,400.00 | 36,147,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 28,225,400.00 | 36,147,400.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 483,844,782.39 | 610,129,099.67 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 483,844,782.39 | 610,129,099.67 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **489,091,149.87** | **677,658,054.95** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **489,091,149.87** | **677,658,054.95** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **488,185,749.87** | **656,052,763.93** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 330,195,483.84 | 482,620,576.80 |
| 210101 | Үндсэн цалин | 261,340,497.21 | 301,539,349.74 |
| 210102 | Нэмэгдэл | 54,223,472.76 | 139,050,873.28 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,196,000.00 | 3,775,000.00 |
| 210104 | Урамшуулал | 11,435,513.87 | 38,255,353.78 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 40,275,770.93 | 59,555,061.55 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,430,952.87 | 41,249,386.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,298,624.87 | 4,849,435.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,612,420.90 | 2,943,214.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 539,433.78 | 2,099,437.06 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,394,338.51 | 8,413,588.30 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,425,400.00 | 31,465,108.98 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,700,000.00 | 3,317,097.48 |
| 210302 | Түлш, халаалт | 21,725,400.00 | 28,148,011.50 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,071,730.00 | 21,858,700.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,647,200.00 | 1,495,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,572,830.00 | 13,745,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 919,000.00 | 869,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 270,700.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,662,000.00 | 5,748,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 47,922,429.50 | 34,757,879.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 36,591,054.50 | 29,312,139.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,760,375.00 | 4,605,740.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,571,000.00 | 840,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,145,000.00 | 11,007,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 176,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,145,000.00 | 10,831,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,654,000.00 | 9,522,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,654,000.00 | 9,522,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,609,355.60 | 2,484,987.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний | 449,062.00 | 985,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | төлбөр хураамж | | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,260,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 108,900.00 | 133,950.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 121,393.60 | 177,593.60 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 545,000.00 | 510,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 70,000.00 | 128,844.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | - | 483,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,886,580.00 | 2,781,450.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,886,580.00 | 2,781,450.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **905,400.00** | **21,605,291.02** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 905,400.00 | 21,498,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 21,498,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 905,400.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 107,291.02 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 107,291.02 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **34,225,352.52** | **(7,673,261.58)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **9,500,000.00** | **710,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **9,500,000.00** | **710,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 9,500,000.00 | 710,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 9,500,000.00 | 710,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(9,500,000.00)** | **(710,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 24,725,352.52 | (8,383,261.58) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **11,149,204.92** | **25,954,839.44** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **25,954,839.44** | **17,571,577.86** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **192,119,629.88** | **31,660,828.08** | **182,412,086.59** | **406,192,544.55** |
| 2 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **192,119,629.88** | **31,660,828.08** | **182,412,086.59** | **406,192,544.55** |
| 3 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -40,707,379.76 | -40,707,379.76 |
| 4 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **192,119,629.88** | **31,660,828.08** | **141,704,706.83** | **365,485,164.79** |
| 5 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **192,119,629.88** | **31,660,828.08** | **141,704,706.83** | **365,485,164.79** |
| 6 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **192,119,629.88** | **31,660,828.08** | **141,704,706.83** | 365,485,164.79 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 76,945,480.31 | **76,945,480.31** |
| 8 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **192,119,629.88** | **31,660,828.08** | **218,650,187.14** | **442,430,645.10** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ЭЗА | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **810,199,200.00** | **676,855,613.93** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **810,199,200.00** | **676,855,613.93** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **788,701,200.00** | **655,357,613.93** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **547,536,000.00** | **482,620,576.80** |
| 210101 | Үндсэн цалин | 317,613,600.00 | 301,539,349.74 |
| 210102 | Нэмэгдэл | 162,585,700.00 | 139,050,873.28 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,193,000.00 | 3,775,000.00 |
| 210104 | Урамшуулал | 53,143,700.00 | 38,255,353.78 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 68,441,900.00 | 59,555,061.55 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,540,500.00 | 41,249,386.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,475,300.00 | 4,849,435.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,737,700.00 | 2,943,214.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,737,700.00 | 2,099,437.06 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,950,700.00 | 8,413,588.30 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 31,572,400.00 | 31,465,108.98 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,350,000.00 | 3,317,097.48 |
| 210302 | Түлш, халаалт | 28,148,100.00 | 28,148,011.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 74,300.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,685,900.00 | 21,858,700.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,602,000.00 | 1,495,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,975,800.00 | 13,745,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,115,500.00 | 869,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 720,600.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,272,000.00 | 5,748,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 55,075,400.00 | 34,757,879.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 45,941,200.00 | 29,312,139.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,389,200.00 | 4,605,740.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,745,000.00 | 840,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 25,491,600.00 | 11,717,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,800,000.00 | 710,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 450,000.00 | 176,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,241,600.00 | 10,831,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 20,000,000.00 | 9,522,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 20,000,000.00 | 9,522,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,398,000.00 | 2,484,987.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,264,000.00 | 985,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 140,000.00 | 133,950.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 300,000.00 | 177,593.60 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 700,000.00 | 510,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 140,000.00 | 128,844.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,068,000.00 | 483,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,500,000.00 | 1,376,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,500,000.00 | 1,376,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 21,498,000.00 | 21,498,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 21,498,000.00 | 21,498,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 21,498,000.00 | 21,498,000.00 |
| 210402 | Тээвэр шатахуун | 1,866,600.00 | 1,866,600.00 |
| **12** | **Татварын бус орлого** | **23,364,600.00** | **23,708,293.70** |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **810,199,200.00** | **669,877,502.35** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **36,147,400.00** | **36,040,108.98** |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 36,147,400.00 | 36,040,108.98 |
| **122** | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | 729,150,600.00 | 610,129,099.67 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 729,150,600.00 | 610,129,099.67 |
| 120010 | Төсөвт байгууллагын өөрийн орлого / туслах / | 23,364,600.00 | 23,708,293.70 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 21,536,600.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **21,536,648.54** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **14,558,536.96** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 56,474.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 1,876.2 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 54,598.6 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг өгсөн байна..

***Залруулсан алдаа:***

Эм боох материалын дансанд тусгай зориулалтын бараа материалыг бүртгэж тайлагнасантай холбоотой 1,876.2 мянган төгрөгийн 1 алдааг  аудитын явцад залруулсан.

***Залруулагдаагүй алдаа:***

Аудитаар нийт 54,598.6 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүллээ.

### 3.1 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-д заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-д /*Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*/, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-д заасныг, мөн үнэлгээ ба хуваарилалт  батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийн талаар авах саналаа холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх тухай зөвлөмж өгсөн. */Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хуулийн хугацаанд ирүүлж, хэрэгжилтийг  2025.06.25-ны өдрийн дотор нотлох баримтын хамт ирүүлэх/*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:**

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Эм боох материалын дансанд тусгай зориулалтын бараа материалыг бүртгэж тайлагнасан. | 1 | 1,876.2 | | | | | 1 | 1,876.2 | | | | |
| **Дүн** | **1** | **1,876.2** | | | | | **1** | **1,876.2** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй. | 1 | 54,598.6 | | | | | 1 | 54,598.6 | | |
| **Дүн** | **1** | **54,598.6** | | | | | **1** | **54,598.6** | **-** | **-** |

**5.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |